

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ГАЗАР



**САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

Хашаат сумын ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** АРА-2021/12/СТА-ТТЗ

**Хаяг:** Архангай аймаг,  
Эрдэнэбулган сум. Аймгийн  
ЗДТГ-ын байр “А” корпус, 3  
давхар зүүн жигүүр.

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2021 он

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр

Утас: 70333141

Цахим хаяг: [ulambayard@audit.gov.mn](mailto:ulambayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860

Цахим хаяг: [baigalmaat@audit.gov.mn](mailto:baigalmaat@audit.gov.mn)

Аудитор: П.Энхжаргал

Утас: 99743112

Цахим хаяг: [enkhjargal@audit.gov.mn](mailto:enkhjargal@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	9
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө .....	10
3.5.2 Авлага .....	10
3.5.6 Бараа материал .....	11
3.5.7 Үндсэн хөрөнгө .....	11
3.5.8 Өр төлбөр .....	12
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо .....	12
3.5.10 Орлогын данс .....	13
3.5.11 Зардлын данс .....	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	14
3.7 Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	17
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	17
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	18
4. Менежментийн захидал .....	18
1.1. Орлогын данстай холбоотой асуудал .....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

## 1. Аудитын гэрчилгээ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2021.08.26 № 124  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Хашаат сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хашаат сумын ТЕЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 82.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

##### Аудитын гол асуудал

Хашаат сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийхэд сум хөгжүүлэх сангаас 2012-2017 онд олгосон 93 зээлдэгчтэй холбоотой 241,913.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллаагүйгээс сангийн хөрөнгийн эх үүсвэрийг дутагдуулж, зээлийн ашиглалтаас бий болох үр нөлөөг бууруулсан, санг хохироосон ноцтой алдаа зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5-д заасан зарчмууд мөн Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих" журмыг тус тус зөрчсөн, "эрх үүрэг", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	617,563.2	731,661.6
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	186,480.9	262,659.9
33	<b>АВЛАГА</b>	318,102.8	309,097.9
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	112,979.5	159,903.8
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	3,399,302.1	4,848,600.2
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,399,302.1	4,848,600.2
39200	Биет хөрөнгө	3,309,561.8	4,760,826.5
39300	Биет бус хөрөнгө	89,740.3	87,773.7
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	4,016,865.4	5,580,261.8
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	68.8	68.8
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	68.8	68.8
41300	Өглөг	68.8	68.8
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	4,016,796.6	5,580,193.0
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,016,796.6	5,580,193.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,700,532.2	2,700,532.2
51200	Хуримтлагдсан үр дүн	279,805.7	1,846,170.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,036,458.7	1,033,490.1
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	4,016,865.4	5,580,261.8

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,765,925.5	4,128,967.0
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	82,944.5	104,510.8
110	Орлогын албан татвар	72,707.2	94,584.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	72,707.2	94,584.4
113	Хөрөнгийн албан татвар	3,115.0	3,180.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,122.2	6,746.4
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	273,421.7	1,853,364.6
120	Нийтлэг татварын бус орлого	273,421.7	1,853,364.6
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,409,559.4	2,171,091.6
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2,554,210.1	2,484,606.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,554,210.1	2,484,606.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,081,637.8	2,393,501.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,347,996.8	1,561,012.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,850.0	195,669.8

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,375.7	75,738.1
2104	Хангамж, бараа материалын зардал	73,948.0	90,450.6
2105	Нормативт зардал	123,680.6	108,469.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,847.8	8,622.7
2107	Томилолт, зочны зардал	7,842.0	2,738.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,937.8	58,193.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	240,159.0	292,607.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	472,572.3	91,105.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	211,715.4	1,644,360.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	118,735.5	80,964.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	92,979.9	1,563,396.4

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,606,130.8	2,437,912.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	82,944.5	104,510.8
110	Орлогын албан татвар	72,707.2	94,584.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	72,707.2	94,584.4
113	Хөрөнгийн албан татвар	3,115.0	3,180.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,122.2	6,746.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,564.2	2,514.5
1181	Газрын төлбөр	3,558.0	4,232.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	113,627.0	162,309.9
120	Нийтлэг татварын бус орлого	113,627.0	162,309.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,409,559.4	2,171,091.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,360,370.6	2,224,123.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,360,370.6	2,224,123.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,887,708.3	2,133,017.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,348,406.7	1,561,012.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,036.2	195,669.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,768.4	73,451.4
2104	Хангамж, бараа материалын зардал	69,409.4	92,460.7
2105	Нормативт зардал	131,441.6	93,301.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,238.2	16,495.8
2107	Томилолт, зочны зардал	7,842.0	2,738.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,524.1	57,928.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,041.7	39,960.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	472,662.3	91,105.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	245,760.2	213,789.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	208,869.9	129,110.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	208,869.9	129,110.2
2200	Дотоод эх үүсвэрээр	208,869.9	129,110.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-208,869.9	-129,110.2

<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-20,000.0	-8,500.0
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	20,000.0	8,500.0
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	16,890.3	76,179.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	169,590.6	186,480.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	186,480.9	262,659.9

#### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,700,532.18	1,036,458.71	186,825.78	3,923,816.66
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,700,532.18	1,036,458.71	186,825.78	3,923,816.66
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	92,979.91	92,979.91
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,700,532.18	1,036,458.71	279,805.69	4,016,796.57
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,700,532.18	1,036,458.71	279,805.69	4,016,796.57
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,968.59	2,968.59
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,700,532.18	1,036,458.71	282,774.28	4,019,765.16
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-2,968.59	0.00	-2,968.59
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,563,396.44	1,563,396.44
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,700,532.18	1,033,490.12	1,846,170.72	5,580,193.02

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл -ийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,456,383.5	2,257,726.4
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,283,454.7	2,168,435.2
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,253,793.2	2,149,051.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,571,186.9	1,560,910.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	212,421.5	195,655.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,847.0	73,451.4
2104	Хангамж, бараа материалын зардал	77,291.7	69,963.6

2105	Нормативт зардал	125,245.7	93,301.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,022.0	22,544.9
2107	Томилолт, зочны зардал	5,072.2	2,738.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,264.5	68,249.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,441.7	62,236.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,661.5	19,383.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,661.5	19,383.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	102,928.8	80,791.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,000.0	8,500.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,456,383.5	2,248,434.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,624,867.1	1,565,003.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	610,247.2	639,170.8
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,681.2	23,925.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	187,588.0	20,334.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	87,176.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	77,885.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	143	141

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32285.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32285.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32285.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	101.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14.5
2104	Хангамж, бараа материалын зардал	23246.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3838.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5085.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32285.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32285.2

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Хашаат сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Э.Нарангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидлаар хүргүүлдэг.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 14-аас 2021 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэв.

Хашаат сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 01/149 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Хашаат сумын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, сумын тогтвортой хөгжлийг хангахад Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, нутгийн захиргааны манлайллыг дээшлүүлэх замаар иргэдэд төрийн чанартай үйлчилгээг үзүүлэх талаар үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулдаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн, байнга суралцагч мэргэшсэн тогтвортой, санаачилгатай цомхон чадварлаг алба байхад оршино” дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хашаат сум нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд төсвийн 8 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж нэгтгэлийг онлайнаар бэлтгэж байна. Хашаат сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөө бага байлаа.

#### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,243,739.2 мянган төгрөгийн 1 хувь буюу 12,437.4 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 2,565,570.5 мянган төгрөгийн 1 хувь буюу 25,655.7 мянган төгрөгөөр тогтоов.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 186,480.9 мянга, эцсийн үлдэгдэл 262,659.9 мянган төгрөг болж, 76,179.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	186,480.9	262,659.9	76,179.0
<b>Дүн</b>	<b>186,480.9</b>	<b>262,659.9</b>	<b>76,179.0</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр:</b>			
Сум хөгжүүлэх сан	47,239.5	57,348.5	10,109.0
Орон нутгийн ерөнхий орлого	99,304.1	184,774.6	85,470.5
Орон нутгийн хөгжлийн сан	39,937.3	20,536.8	-19,400.5
<b>НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>186,480.9</b>	<b>262,659.9</b>	<b>76,179.0</b>

Эх сурвалж: Хашаат сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 70.3 хувь буюу 184,774.6 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны, 21.8 хувь буюу 57,348.5 мянган төгрөг нь ОНХСангийн, 7.8 хувь буюу 20,536.8 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 318,575.1 мянга, эцсийн үлдэгдэл 309,097.9 мянган төгрөг болж, 9,004.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн авлага	315,575.1	306,570.2	9,004.9
Ахлах сургууль	2,527.7	2,527.7	-
<b>Дүн</b>	<b>318,102.8</b>	<b>309,097.9</b>	<b>9,004.9</b>

Эх сурвалж: Хашаат сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын төсөвт байгууллагууд авлагын үлдэгдэлгүй бөгөөд СХС-ийн үлдэгдэл 306,570.2 мянган төгрөг байна.

СХСангийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 64,657.0 мянган төгрөг буюу 21.1 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 37,432.5 мянган төгрөг буюу 12.2 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 204,480.7 мянган төгрөг буюу 66.7 хувь нь чанаргүй зээл байна.

**Аудитын илрүүлэлт:** Хашаат сумын ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн тайланд аудит хийхэд сум хөгжүүлэх сангаас 2012-2017 онд олгосон 93 зээлдэгчтэй холбоотой 241,913.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллаагүйгээс сангийн хөрөнгийн эх үүсвэрийг дутагдуулж, зээлийн ашиглалтаас бий болох үр нөлөөг бууруулсан, санг хохироосон алдаа зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5-д заасан

зарчмууд мөн Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг тус тус зөрчсөн байна.

### 3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 235,507.0 мянга, эцсийн үлдэгдэл 234,175.2 мянган төгрөг болж, 1,331.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	1,713.0	1,713.0	-
Эм боох материал	5,061.7	19,126.7	14,065.0
Бичиг хэргийн материал	18,644.9	27,382.6	8,737.7
Аж ахуйн материал	68,626.4	86,692.7	18,066.3
Сэлбэг хэрэгсэл	5,177.4	2,786.0	-2,391.4
Түлш, шатах тослох материал	7,309.2	5,022.5	-2,286.7
Барилгын засварын материал	4,669.0	16,043.6	11,374.6
Хүнсний материал	1,385.7	744.5	-641.2
Бусад хангамжийн материал	392.2	392.2	-
<b>Дүн</b>	<b>112,979.5</b>	<b>159,903.8</b>	<b>46,924.3</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Ахлах сургууль	47,015.9	68,853.6	21,837.7
ЗДТГ	21,661.8	27,562.1	5,900.3
ИТХ	316.8	499.8	183.0
Соёлын төв	3,701.6	3,543.7	-157.9
Цэцэрлэг	8,971.7	14,825.1	5,853.4
ЭМТ	30,919.5	44,227.3	13,307.8
Сум хөгжүүлэх сан	392.2	392.2	-
<b>Дүн</b>	<b>112,979.5</b>	<b>159,903.8</b>	<b>46,924.3</b>

Эх сурвалж: Хашаат сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл нийт дүнгээр 46,925.3 мянган төгрөгөөр өссөн боловч нэр төрлөөр авч үзвэл түүхий эд материал 14,065.0 мянган төгрөгөөр, хангамжийн материал 32,859.3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Түүхий эд материалын өсөлт нь ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор эм боох материалын нөөц бэлтгэсэнтэй холбоотой байна.

Нийт бараа материалын 43.1 хувь буюу 68,853.6 мянган төгрөг нь ахлах сургуулийн, 27.7 хувь буюу 44,227.3 мянган төгрөг нь ЭМТ-ийн, 17.2 хувь буюу 27,562.1 мянган төгрөг нь ЗДТГ-ын, 0.2-9.3 хувь буюу 392.2-14,825.1 мянган төгрөг нь бусад төсөвт байгууллагуудын бараа материал байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Сум хөгжүүлэх сан- Өвс тэжээлийн 392.2 мянган төгрөгийн бараа материал нь эд хөрөнгийн тооллогын бүртгэлд байхгүй, бодитоор оршин байхгүй байна.

Эрүүл мэндийн төв- Үнэ төлбөргүй хандив тусламжаар ирсэн эмийн үнэд өөрчлөлт орсон тул бараа материалын тайланд 6,900.6 мянган төгрөгөөр залруулга хийсэн.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,399,302.1 мянга, эцсийн үлдэгдэл 4,848,600.2 мянган төгрөг болж, 1,449,298.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,309,561.8	4,760,826.5	1,451,264.7
Биет бус хөрөнгө	89,740.3	87,773.7	-1,966.6
<b>Дүн</b>	<b>3,399,302.1</b>	<b>4,848,600.2</b>	<b>1,449,298.1</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
Ахлах сургууль	1,730,894.1	1,714,145.9	-16,748.2
ЗДТГ	839,314.6	1,018,770.7	179,456.1
ИТХ	1,711.7	12,090.1	10,378.4
Соёлын төв	45,098.1	1,327,986.4	1,282,888.3
Хүүхдийн цэцэрлэг	285,950.8	292,834.0	6,883.2
ЭМТ	496,332.8	482,773.1	-13,559.7
<b>Дүн</b>	<b>3,399,302.1</b>	<b>4,848,600.2</b>	<b>1,449,298.1</b>

Эх сурвалж: Хашаат сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 48,319.0 мянга, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,666,481.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 47,587.6 мянган төгрөгөөр хасагдсан байна. Тайлант онд нийт 265,329.2 мянган төгрөгийн элэгдэл тооцогдсноос акталсан хөрөнгийн 47,414.8 мянган төгрөгийн элэгдэл хасагдаад нийт 217,914.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсан байна.

Аудитын илрүүлэлт: 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ЭМТ-ийн- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн нийт 28,794.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь ТБОНӨТХ-ийн 31 дэхь заалт, Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны заавартай нийцэхгүй байна. Хүүхдийн цэцэрлэгийн элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн нийт 5210.0 мянган төгрөгийн хөрөнгө,
- Ахлах сургуулийн элэгдлээ бүрэн нөхсөн 97ш хөрөнгө байгааг өмч хамгаалал байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн цаашид ашиглагдах боломжит хугацаа болон холбогдох нөхцөлийг хэлэлцүүлээгүй

### 3.5.8 Өр төлбөр

Хашаат сумын сум хөгжүүлэх сан нь 68.8 мянган төгрөгийн өглөгтэй байна. Тухайн байгууллагын санхүүгийн ажилтнаас тодруулахад олон жилийн насжилттай, эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон байна.

Хүснэгт № 5 Өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Байгууллагад төлөх өглөг	68.8	68.8	-
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
СХСан	68.8	68.8	-
<b>ДҮН</b>	<b>68.8</b>	<b>68.8</b>	<b>-</b>

Эх сурвалж: Хашаат сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,016,796.6 мянга, эцсийн үлдэгдэл 5,580,193.0 мянган төгрөг болж, 1,563,396.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,700,532.2	2,700,532.2	-
<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	2,700,532.2	2,700,532.2	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	279,805.7	1,846,170.7	1,566,365.0
<b>Өмнөх үеийн үр дүн</b>	186,825.8	282,774.3	95,948.5
<b>Тайлант үеийн үр дүн</b>	92,979.9	1,563,396.4	1,470,416.5
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	1,036,458.7	1,033,490.1	-2,968.6
<b>Дүн</b>	4,016,796.6	5,580,193.0	1,563,396.4
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>			
<b>Төсөвт байгууллага</b>	3,613,721.2	5,195,414.1	1,581,692.9
<b>Төсөл, сан</b>	403,075.4	384,778.9	-18,296.5
<b>Дүн</b>	4,016,796.6	5,580,193.0	1,563,396.4

Эх сурвалж: Хашаат сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,580,193.0 мянган төгрөг болж 1,563,396.4 мянган төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1,033,490.1 мянган төгрөг болж 2,968.6 мянган төгрөгөөр буурсан нь актлагдсан үндсэн хөрөнгөөс шалтгаалжээ.

### 3.5.10 Орлогын данс

Хашаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 4,128,967.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 1,363,041.5 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 480,494.0 мянган төгрөгийн устгах бичилт хийгдсэн байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

- Татварын орлого 104,510.8 мянган төгрөг,
- Татварын бус орлого 1,853,364.6 мянган төгрөг байна. Үүнээс: Хүү торгуулийн орлого 141,975.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 2,830.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1,708,559.6 мянган төгрөг байна.
- Тусламж санхүүжилтийн орлого 2,171,091.6 мянган төгрөг байна. Үүнээс: улсын төсвөөс 1,620,051.5 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих 23,925.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 32,285.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 484,829.3 мянган төгрөг байна.

### 3.5.11 Зардлын данс

Хашаат сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 2,484,606.6 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 80,964.0 мянган төгрөг, нийт 2,565,570.6 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос 1,563,396.4 мянган болж өссөн нь үнэ төлбөргүй хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалсан байна. Тайлант жилд 480,494.0 мянган төгрөгийн давхардсан гүйлгээг устгах бичилт хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ИТХ-ын төсвийн "Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж" буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас аймгийн Цагдаагийн газарт авто машин худалдан авахад 12000.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6. "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтыг зөрчиж байна.

- Ерөнхий боловсролын сургуулийн нийт ажил гүйлгээнээс түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн 9,315.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Орон нутгийн төсвийн орлогыг 121,216.9 мянган төгрөгөөр анх төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг 35,658.9 мянган төгрөгөөр бууруулан 85,558.0 мянган төгрөгөөр анх баталсан байна.

Хашаат сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 04 дугаар тогтоолоор тухайн сум тайлант онд 116,418.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 247,533.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.1 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 6. Сумын орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
<b>1.НИЙТ ОРЛОГО</b>	<b>116,418.0</b>	<b>247,533.8</b>	<b>131,115.8</b>	<b>212.6</b>
<b>2.УРСГАЛ ОРЛОГО</b>	<b>116,418.0</b>	<b>247,533.8</b>	<b>131,115.8</b>	<b>212.6</b>
<b>3.ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>69,918.0</b>	<b>104,510.8</b>	<b>34,592.8</b>	<b>149.5</b>
4.Орлогын албан татвар	61,410.0	94,584.3	33,174.3	154.0
Хүн амын орлогын албан татвар	61,410.0	94,584.3	33,174.3	154.0
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар			-	
Үйл ажиллагааны орлого	1,800.00	2,044.20	244.2	113.6
Хөрөнгийн орлого	25,000.00	35,779.20	10,779.2	143.1
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	150	1888.6	1,738.6	1,259.1
Шууд бус орлого	34,460.00	54,872.30	20,412.3	159.2
<b>Өмчийн татвар</b>	<b>3,150.00</b>	<b>3,180.00</b>	<b>30.0</b>	<b>101.0</b>
Үл хөдлөх хөрөнгийн татвар			-	
Бууны албан татвар	3,150.00	3,180.00	30.0	101.0
<b>Бусад татвар</b>	<b>5,358.00</b>	<b>6,746.50</b>	<b>1,388.5</b>	<b>125.9</b>
Улсын тэмдэгтийн хураамж	1,480.00	653.50	(826.5)	44.2
Газрын төлбөр:	1194	4232	3,038.0	354.4
Газрын төлбөр		236.8	236.8	
Газрын дуудлага худалдааны орлого	1194	3995.2	2,801.2	334.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	200	200	-	100.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,484.00	1,661.00	(823.0)	66.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр:			-	
Байгалийн ургамал ашигласны төлбөр			-	
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр			-	
Ойн нөөц ашигласны төлбөр			-	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр			-	
<b>5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,500.00</b>	<b>143,023.00</b>	<b>96,523.0</b>	<b>307.6</b>
Төсөвт газрын өөрийн орлого	1000	1048	48.0	104.8
Хүү, торгуулийн орлого	45000	141,971.00	96,971.0	315.5
Нэр заагдаагүй бусад орлого	500	4	(496.0)	0.8

**Аудитын илрүүлэлт:** Орлого нийт дүнгээрээ давж биелсэн боловч 3 нэр төрлийн орлого 2,145.5 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Улсын тэмдэгтийн хураамж 826.5 мянган төгрөгөөр,
2. Хог хаягдлын хураамжийн орлого 823.0 мянган төгрөгөөр,
3. Нэр заагдаагүй бусад орлого 496.0 мянган төгрөгөөр,

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

### Төсвийн төлөвлөлт

Хашаат сумын ИТХ-ын 2020 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 2,602,302.6 мянган төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор 2,458,883.5 мянган төгрөг болж 143,419.1 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Хүснэгт 7. Сумын төсвийн төлөвлөлт

/мянган төгрөг/

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн татварын орлого	85,558.0	116,418.0	30,860.0
2	ТЕЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	73,050.0	73,050.0	0.0
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	304,949.3	262,673.3	-42,276.0
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	64,561.4	61,390.8	-3,170.6
5	СӨБ-ийн үйлчилгээ	290,729.2	257,783.6	-32,945.6
6	ЕБС-ийн үйлчилгээ	1,125,846.6	1,033,113.9	-92,732.7
7	Соёлын үйлчилгээ	99,529.7	97,529.7	-2,000.0
8	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	444,540.5	443,386.2	-1,154.3
9	2019 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	74,000.0	74,000.0	0.0
10	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	39,538.0	39,538.0	0.0
	<b>Нийт дүн</b>	<b>2,602,302.6</b>	<b>2,458,883.5</b>	<b>-143,419.1</b>
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	90,177.5	90,177.5	0.0
2	Засаг даргын тамгын газар	374,329.7	362,913.8	-11,415.9
3	Орон нутгийн хөгжлийн сан	104,099.4	100,928.8	-3,170.6
4	Сум хөгжүүлэх сан	71,050.0	71,050.0	0.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	290,729.2	257,783.6	-32,945.6
6	Ерөнхий боловсролын сургууль	1,125,846.6	1,033,113.9	-92,732.7
7	Соёлын төв	101,529.7	99,529.7	-2,000.0
8	Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ	444,540.5	443,386.2	-1,154.3
	<b>Нийт дүн</b>	<b>2,602,302.6</b>	<b>2,458,883.5</b>	<b>-143,419.1</b>

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн зарим нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн баталсан бол

1. ЭМТ-ийн тогтмол зардал 1,154.3 мянган төгрөгөөр,
2. Аймагт ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл цуцлагдаж орох орлого буурсан зэрэгтэй уялдуулан орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 3,170.6 мянган төгрөгөөр
3. ЗДТГ-Цар тахалтайгаар холбоотойгоор зочин төлөөлөгч хүлээн авалт, албан томилолт тавилга, эд хогшил, урсгал засвар зэрэг тэвчиж болох зардлуудыг 11,415.9 мянган төгрөгөөр
4. Ковид-19 цар тахалтай холбогдуулан соёлын төвийн өөрийн орлогыг 2000.0 мянган төгрөгөөр

5. Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын /сургууль, цэцэрлэг/ үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс 125,678.3 мянган төгрөгөөр тус тус хасаж тодотгол хийгдсэн байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 2,456,383.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,283,454.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 102,928.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 70,000.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 723,785.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 33,681.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,624,867.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгээс, 74,050.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Харин төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,257,726.4 мянган төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь урсгал зардлаас 115,019.5 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 22,137.6 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангаас 61,500.0 мянган төгрөг хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17 төсөл, арга хэмжээнд 100,928.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 15 арга хэмжээ бүрэн хэрэгжиж гүйцэтгэлээр 86,028.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 2 арга хэмжээ хэрэгжээгүйгээс 14,900.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 28,311.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,973.7 мянга, нийт 32,285.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, тэтгэмжийн зардалд 116.0 мянга, хангамж, бараа материалын зардалд 23,246.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 3,838.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 5,085.0 мянга, нийт 32,285.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

#### **Аудитын илрүүлэлт:**

- ТЕЗ- Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.
- Ахлах сургууль- Шилэн дансны хуулийн дагуу 148 мэдээлэл оруулахаас 13 мэдээлэл хугацаа хоцроосон
- Хүүхдийн цэцэрлэг- Шилэн дансны цахим сайтад нийт 148 мэдээлэл байршуулахаас 125 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 50,992.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Зөвлөмж</b>	2	283,300.3	1	5,708.8	1	277,591.5	50%
<b>Нийт</b>	<b>2</b>	<b>283,300.3</b>	<b>1</b>	<b>5,708.8</b>	<b>1</b>	<b>277,591.5</b>	<b>50%</b>

Өмнөх санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар СХС-ийн авлагыг барагдуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

### 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдаж, 1 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуулын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, сумын ИТХ-д “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн байна. Хүснэгтээр харуулвал:

Хүснэгт №9.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл		
	Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс	
		Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн		Зөрчилгүй	Хязгаарлалттай
Ахлах сургууль	1	1			1	1	
Хүүхдийн цэцэрлэг	1	1			1	1	
ЗДТГ	1			1	1		
ИТХурал	1	1			1		1
Эрүүл мэндийн төв	1	1			1	1	
Соёлын төв	1		1				
ОНХС	1		1				
СХС	1		1				
<b>НИЙТ ДҮН</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>1</b>

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 57,010.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 6,900.6 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 12,000.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 28,794.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.

Хүснэгт №10. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчил		Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт			
							Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахлах сургууль	3	9,315.4			3	9315.4	1		2	9315.4
Хүүхдийн цэцэрлэг	2	0.0			2				2	
ИТХурал	2	12,000.0			2	12,000.0	1	12,000.0	1	
Эрүүл мэндийн төв	3	35,695.0	1	6,900.6	2	28,794.4			2	28,794.4
<b>НИЙТ ДҮН</b>	<b>10</b>	<b>57,010.4</b>	<b>1</b>	<b>6,900.6</b>	<b>9</b>	<b>50,109.8</b>	<b>2</b>	<b>12,000.0</b>	<b>7</b>	<b>38,109.8</b>

Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумын ИТХ-ын төсвийн "Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж" буюу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас аймгийн Цагдаагийн газарт авто машин худалдан авахад 12000.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6. "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх", мөн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байсныг анхаарч үзэх нь зүйтэй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1.1. Орлогын данстай холбоотой асуудал

#### 1.1.1 Илрүүлэлт:

Орон нутгийн 14 нэр төрлийн орлогоос 3 нэр төрлийн орлого 2,145.5 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1. Улсын тэмдэгтийн хураамж 826.5 мянган төгрөгөөр,
2. Хог хаягдлын хураамжийн орлого 823.0 мянган төгрөгөөр,
3. Нэр заагдаагүй бусад орлого 496.0 мянган төгрөгөөр,

Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### 1.1.2 Эрсдэл:

- Сумын ИТХ-аар баталсан Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө орлогын нэр төрлөөр биелэгдээгүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байх
- Орон нутгийн Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэхгүй байх

#### 1.1.3 Өгсөн зөвлөмж:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах
- Орлого тасарч байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох

Хашаат сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**1.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

**2.1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

**2.1.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна

**2.1.2. Эрсдэл:**

Шилэн дансны тухай хууль хэрэгжихгүй байх, мэдээллийн ил тод байдал хангагдахгүй байх

**2.1.3. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6.2.4. "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт" гэсэн заалтыг хэрэгжүүлэн мэдээллийг хугацаанд нь шилэн дансанд мэдээлж ажиллах

**2.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 12 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**АУДИТЫН ТАЙЛАН**

Бэлтгэсэн:	Аудитор		П.Энхжаргал
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Т.Байгалмаа
Хоёр дахь шатанд хянасан:	Тэргүүлэх аудитор		Д.Уламбаяр

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	Хашаат сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудит	<b>Аудитын код:</b>
2021			АРА-2021/12/СТА-ТТ3
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Хашаат сумын ТЕЗ		<b>Сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны		
			Нэр	Албан тушаал	Овог нэр	
1	Орон нутгийн 14 нэр төрлийн орлогоос 3 нэр төрлийн орлого 2,145.5 мянган төгрөгөөр тасарсан байна.	2,145.5	Зөвлөмж хүргүүлэв	Засаг Санхүү дарга	дарга, албаны	Э.Нарангэрэл, Д.Болдбаатар
2	Сум хөгжүүлэх сангаас олгосон 241,913.2 мянган төгрөгийн 21 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна	241,913.2	Албан шаардлага хүргүүлэв	Засаг Санхүү дарга	дарга, албаны	Э.Нарангэрэл, Д.Болдбаатар
3	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 139 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна		Зөвлөмж хүргүүлэв	Засаг Санхүү дарга	дарга, албаны	Э.Нарангэрэл, Д.Болдбаатар
	<b>Дүн</b>	244,058.7				